

## БНСУ-ЫН ҮНДСЭН ХУУЛЬ

*Н.Бямбадорж\**

### **I. Товч танилцуулга**

Бүгд Найрамдах Солонгос Улс нь /БНСУ/ нь Ази тивийн зүүн хойт хэсэгт оршдог, 99,237 км<sup>2</sup> газар нутагтай нь Солонгосын хойгийн 45 хувь нь гэсэн үг юм. Газар нутаг нь хойноосоо урагшаа 100 км сунаж тогтсон байрлалтай. 48 сая хүн амтай. Нийслэл Сөүл 11 сая хүнтэй, хүн амын 65,4 хувь нь хотод оршин суудаг. Өнөөгийн байдлаар сая түүнээс дээш хүн амтай хот 5 байна. Шашин шүтлэгийн хувьд олон янз, зонхилох нь христос, бурханы шашин болно. БНСУ-ын хууль тогтоох төрийн дээд байгууллага нь нэг танхимт үндэсний Ассамблей юм. Тус улс нь парламентийн системтэй улс болж байсан ч энэ нь зөвхөн 1 жил /1960-1961/ оршин тогтносон байна. Үүнээс хойш Бүгд Найрамдах Улс ерөнхийлөгчийн засаглалтай болов. БНСУ-ын төрийн тэргүүн нь ерөнхийлөгч болно. Тус улсын Үндсэн хуулиар дотоод, гадаад бодлогын салбарт ерөнхийлөгч өргөн эрх мэдэлтэй байдаг. Ерөнхийлөгчийг таван жилийн хугацаатай сонгодог, дахин сонгогдох эрх эдэлдэггүй байна.

БНСУ засаг захиргааны хувьд Сиенгги, Кангвон, Чунченгнам, Чунгченгбук, Чолланам, Киенгсангнам, Киенгсанчбук, Чэжүгэсэн 9 муж, нийтдээ 56 дүүрэг бүхий 6 томоохон хотоос бүрдэл болно. Өмнөд Солонгос өнөөдрийн байдлаар 123 хот, 36000 тосгонтой.

Улс орны нийгэм, эдийн засгийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг саяас дээш хүн амтай аж үйлдвэрийн томоохон төв болсон хотууд гэвэл 22 дүүрэгтэй Сөүл, 12 дүүрэгтэй Пусан, 7 дүүрэгтэй Тэгү, 6 дүүрэгтэй Инчон, 4 дүүрэгтэй Куанжу, 3 дүүрэгтэй Тэнжэн хот юм.

Өмнөд Солонгос баруугаараа Шар тэнгис, зүүгээрээ Дорнод тэнгис, өмнүүрээ Япон тэнгисээр хүрээлэгдэнэ. Газар нутгийн 70 хувийг уул нуруу эзлэнэ. Уулсын хамгийн өндөр нь далайн түвшнээс дээш 2744 метр өргөгдсөн. Солонгост том жижиг 3000 арал бий. Үүнээс хамгийн том нь Монголчуудын түүхэнд холбогдох Чэжү арал юм. Гол төлөв хойноосоо урагш чиглэн урсдаг Амнок /790 км/, Түмэн /521/, Нактонг /525 км/, Хан /514 км/ зэрэг томоохон гол мөрөнтэй. Эдгээр гол мөрөн улс ардын аж ахуйд чухал үүрэг гүйцэтгэдэг. Далайн зөөлөн дулаан, чийглэг уур амьсгалтай. Өвөлдөө -12 хэм хүйтэрч, зундаа 36,6 хэм хална. Борооны улирал нь 7, 8-р сар юм. Байгалийн баялаг хомс. Гянт болд, анзан, цайр, бал, шөрмөсөн чулуу, каолин зэргээс бусад эрдэсээр ховор. Улс орны эдийн засагт эн тэргүүний онцгой чухал хэрэгцээт түлш, төмөр, хөнгөн цагаан зэрэг 29 төрлийн түүхийн эдийг гадаадаас 90-100 хувь авдаг.

\* Н.Бямбадорж - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Байгалийн нөөц баялгаар хомс ч газар зүйн ашигтай байрлалд оршдог. Өмнөд Солонгос дэлхийн хотуудын төв хэмээн нэрлэгддэг Токиотой бусад аль ч орныхоос ойр оршдог. Дэлхийн хамгийн том зах зээлд тооцогддог Бээжинтэй хаяа дэрлэдэг. Токио Бээжинг шулуун шугамаар холбоход бараг голд нь Сөүл хот оршино. Энэ бүхнээс үзэхэд Солонгос орон дорнын соёлын их замын нэгэн томоохон буурчийн газар гэлтэй. Өнөөдөр энэ замаар Японы шинжлэх ухааны техникийн орчин үеийн шинэхэн нээлт ололт Солонгосыг дайран Хятад улсад хүрч байна. Энэ орныг Зүүн хойт Азийн бүс нутаг гэдэг ойлголтын үүднээс аваад үзсэн ч АНУ, Япон, Хятадыг холбосон том гурвалжны төв хэсэгт БНСУ байрлаж байна.

Дундад зууны үед Солонгосын ард түмэн харийн булаан эзлэгчдийн эсрэг нэг бус удаа зэвсэг барин тэмцэж байсан түүхтэй. Япон улс 1876 онд Солонгост анхны тэгш бус худалдааны хэлэлцээрийг тулган хүлээлгэж 1905 оны арван нэгдүгээр сард өөрийн захиргааг тогтоож, улмаар 1910 онд “Солонгосыг нийлүүлэх тухай гэрээ” байгуулж Японы нэг муж гэж зарлажээ. Тэр цагаас хойш Солонгос орон 1945 оны наймдугаар сар хүртэл Японы ноёрхолд байсан байна. 1945 онд колоничлолоос ангижирсан боловч аанай л том гүрнүүдийн сөргөлдөөнд өртөж Солонгосын хойг хоёр хуваагджээ. Чухам энэ үеэс буюу 1948 оноос Сөүл нийслэлтэй БНСУ-ын шинэхэн түүх эхэлсэн билээ.

Энэ үеийн Өмнөд Солонгосын нийгэм-эдийн засгийн амьдрал үнэхээр хүнд хэцүү байв. Хуваагдмал нөхцөлд улс орноо төвхнүүлэх, эдийн засгаа өөд татаж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг амаргүй зорилт тавьж амжилттай хэрэгжүүлсэн болно.

## **II. Эрх зүйн тогтолцооны уламжлал**

БНСУ-ын орчин үеийн эрх зүйн тогтолцоо нь Ром-Германы эрх зүйн бүлэгт багтах ч Америкийн эрх зүйгээс нэлээд зүйлийг авсан байдаг. Тэгэхдээ Солонгосчуудын эрх зүйн ухамсар, эрх зүйн соёл нь урьдын адил Дорнод Азийн ард түмнүүдийн хувьд нийтлэг шинжтэй кунзийн сургаалийн уламжлал болох хамтач үзэл, эцгийн эрхт ёс, ёс зүйн хэм хэмжээ нь хууль зүйнхийг, үүрэг нь эрхийг давамгайлах байдалтай, шүүх хуралдааны өмнө албан ёсны бус журмын дагуу эвлэрэхийг илүүтэйд үздэг зэрэгт үлэмжхэн хэмжээгээр тулгуурладаг байна.

БНСУ нь олон зуун жилийн турш Хятадын /кунз/ төр эрх зүйн соёлын нөлөөн дор байсны улмаас жинхэнэ эрх зүйн заалт нь гол төлөв эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр хязгаарлагдаж байлаа. Нийгмийн харилцааны үндсэн хэсэг нь ёс суртахуун – ёс зүйн хэмжээ болон зан заншил, уламжлалаар зохицуулагдаж байсны зэрэгцээ Дундад зууны үеийн Солонгост Хятадын хуулиудыг авч хэрэглэж, эрх зүйн өвөрмөц актуудыг батлан гаргасан байна.

Солонгос улс нь Ром-Германы эрх зүйн жорыг анх авч хэрэглэсэн түүх нь XIX зууны сүүлч үеэс эхэлсэн шинэчлэлийн болон Японы колоничлолын үед /1910-1945/ Японы хууль тогтоомжийг ашиглах болсноор “дамжин” хэрэгжиж эхэлсэн гэж үздэг. Үүний зэрэгцээ Японы түрэмгийлэн эзлэлтийн үед Солонгосын заншлын эрх зүйн нь гэр бүлийн харилцаа, өв залгамжлалын хүрээний эрх зүйн гол эх сурвалжийн үүргийг гүйцэтгэж ирсэн байна.

1945 онд тусгаар тогтнолоо олж авсны дараа Японы бүх хууль, төрөлжүүлсэн хуулиудыг Солонгос улсынхаар халж сольсон байна. Тухайлбал: Эрүүгийн төрөлжүүлсэн хууль /1953/, Эрүүгийн байцаан шийтгэх төрөлжүүлсэн хууль /1954/, Иргэний төрөлжүүлсэн хууль /1958/, Иргэний байцаан шийтгэх төрөлжүүлсэн хууль /1962/ болон хууль тогтоогчид нь Японы урьд өмнөх актаас салахыг зориуд хичээн байж боловсруулсан өөр хэд хэдэн хууль батлагдсан байна. Хэдий тийм боловч хамгийн чухал салбар, институтэд Өмнөд Солонгосын эрх зүй нь Ром-Германы эрх зүйн үндсэн зарчим, шинжийг Японы хууль тогтоомжоор дамжуулан авсан тэр хэвээрээ хадгалагдан үлджээ.

1945-1948 онд Сөүлийн засгийн газар ерөнхийдөө АНУ-тай ойртохыг ерөнхий чиг баримжаагаа болгож байсны үр дүнд Солонгосын эрх зүйн тогтолцоо нь дайны дараахь хугацаанд Америкийн эрх зүйн шинжийг ялангуяа захиргааны, худалдааны, хөдөлмөрийн, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд авч ажиллаж байсан байна.

1980-1990 оны үед Өмнөд Солонгосын эрх зүйн тогтолцоонд оруулсан нэн чухал өөрчлөлт нь уг тогтолцоог ардчилахтай холбоотой байсан юм.

Ингээд БНСУ-ын үндсэн хуулийг хэдэн онд хэдэн удаа ямар үе шаттайгаар баталдаг болохыг дор үзүүлэв.

### **III. БНСУ-ЫН ҮНДСЭН ХУУЛЬ**

БНСУ-ын Үндсэн хууль нь ард түмний нийтлэг эрхийг хамгаалах бөгөөд, улс орны үндсэн гол хэм хэмжээг тодотгосон хамгийн дээд хууль юм. Үндсэн хууль нь:

1-рт. Улс орны ерөнхий зохицуулалт болж хэм хэмжээг мөрдүүлэх.

2-рт. Хүн ардын нэр төр, аз жаргалтай амьдрах эрх, хүний эрх, эрх чөлөө, үүргийг журамлаж өгнө гэж тодорхойлсон байна.

Үндсэн хуулиа өөрчлөн батлаж байсан түүхэн цаг хугацаа:

БНСУ-ын одоогийн мөрдөж байгаа Үндсэн хууль нь нийт 10 бүлэг, 130 зүйлтэй бөгөөд нэмэлт 6 зүйлтэйгээр мөрдөгдөж байна.

1. 1948-7-17 : Ерөнхийлөгчийн засаглалыг байгуулж, нэг танхимтай УИХ-ыг байгуулсан

2. 1952-7-7 :ИХ-ын хоёр танхимтай болсон.
3. 1954-11-29: Ерөнхийлөгч, ерөнхий сайдын статусыг халсан.
4. 1960-6-15: Засгийн газрыг баталсан.
5. 1960-11-29: Хууль бус сонгогдогчыг яллах болсон
6. 1962-12-20: Ерөнхийлөгчийн засаглалтай болж, ИХ нь нэг танхимтай болсон.
7. 1969-10-21: УИХ-ын гишүүн давхар ажил эрхлэхийг хориглосон.
8. 1972-12-17: Шууд ерөнхийлөгчийн засаглалтай болсон.
9. 1980-10-27: Ерөнхийлөгчийг 7 жилийн хугацаатайгаар сонгох болсон бөгөөд УИХ-ын гишүүдийг хувь тэнцүүлэх системээр сонгох саналыг хүлээн авсан.
10. 1987-10-29: Ерөнхийлөгчийг 5 жилээр сонгох болсон.

1987 оны Үндсэн хууль нь олон шатлалт сонгуулийн оронд Ерөнхийлөгчийн шууд сонгуулийг бий болгож, парламентын эрхийг өргөжүүлэн ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хягаарлаж, уг албан тушаалыг хаших хугацаа 7 жил байсныг 5 жил болгосон байна. Мөн хэвлэлийн эрх чөлөө, үйлдвэрчний эвлэл байгуулах, жагсаал цуглаан хийх эрхийг бататгаж улс төрийн бодлогод армийг оролцуулахгүй байх заалтыг Үндсэн хуульд оруулж өгсөн.

1988 оны эцсээр Үндсэн хуулийн шүүх байгуулагдаж ажилдаа орсон байна. БНСУ-ын Үндсэн хуульд тусгагдсан зүйл заалтууд:

- 1-р бүлэгт: Нийтлэг үндэслэл /1-9 зүйл/
  - 2-р бүлэгт: Ард түмний эрх, үүргийн талаар /10-39 зүйл/
  - 3-р бүлэгт: УИХ /40-65 зүйл/
  - 4-р бүлэгт: Засгийн газар /66-100 зүйл/
  - 1-р хэсэгт: Ерөнхийлөгч /66-85 зүйл/
  - 2-р хэсэгт: Засаг захиргаа /86-100 зүйл/
  - 1-р заалт: Ерөнхий сайд болон гишүүд /86-87 зүйл/
  - 2-р заалт: Төрийн хурал /88-93 зүйл/
  - 3-р заалт: Засаг захиргааны хэлтэс /94-96 зүйл/
  - 4-р заалт: Хяналт шалгалт /97-100 зүйл/
  - 5-р бүлэг: Шүүх /101-110 зүйл/
  - 6-р бүлэг: Үндсэн хуулийн шүүх /111-113 зүйл/
  - 7-р бүлэг: Сонгуулийн удирдлага /114-116 зүйл/
  - 8-р бүлэг: Орон нутгийн удирдлага /117-118 зүйл/
  - 9-р бүлэг: Эдийн засаг /119-129 зүйл/
  - 10-р бүлэг: Үндсэн хуулийн өөрчлөлт / 128 – 130 зүйл/
- Нэмэлт 6 зүйлтэй.

#### Үндсэн хуулийг батлах үе шат

1. Санал гаргах: Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүдийн дийлэх олонхи дэмжсэн байх.

2. Албан ёсоор мэдэгдэх: Ерөнхийлөгч 20 хоногт албан ёсоор зарлана.
3. УИХ шийдвэр гаргах: Албан ёсоор зарлагдснаас 60 хоногийн дотор УИХ-ын гишүүдийн 3/2 –оос илүү хувиар дэмжигдсэн тохиолдолд УИХ шийдвэр гаргана.
4. Ард түмний санал асуулга: УИХ-аас шийдвэр гарснаас 30 хоногийн дотор ард түмний санал асуулга явуулна /Сонгууль өгөх эрхтэй субъектүүдийн дийлэнх олны санал байх шаарлагатай/
5. Тунхаглах: Ард түмний саналын дараа дүнг Ерөнхийлөгч шууд нийтэд зарладаг байна.

Судлаач миний зүгээс үзэхэд, БНСУ нь капиталист орны хувьд Үндсэн хуулиа харьцангуй олон удаа өөрчилсөн байх юм. Энэ үндсэн хуулиудын өөрчлөлтийг харахад тус улс нь улс орон болон ард түмэнд ямархуу эрх зүйн хэм хэмжээ хэрэгтэй байгааг нарийн мэдрэмжтэй хүлээн авч үндсэн хуулиа өөрчлөх аргаар зохицуулж байсан байна. Манай Монгол улс ч гэсэн энэ улс шиг, гол гол асуудал болох уул уурхайн салбарыг үндсэн хуулиараа зохицуулж өгвөл зохилтой. Яагаад гэвэл энэ нь манай улсын ард түмэн цаашид баяжих уу, ядуурах уу гэдгийг шийдэх үнэхээр гол асуудал юм.

Хамгийн сүүлд Ну Мү Хён ёрөнхийлөгч 2007 онд үндсэн хуульд өөрчлөлт оруулах талаар санал гаргасан ч олон нийтийн санал авч чадаагүй юм.

БНСУ-ын ерөнхийлөгчийн 17 дахь удаагийн сонгууль 2007 оны 12-р сард болж Сөүл хотын засаг даргаар ажиллаж байсан Ли Мён Бак нийт сонгогчдын 42%-ийн саналаар ялалт байгуулан ерөнхийлөгч болсон байна.

### **Ашигласан материал**

1. С.Нарангэрэл “Олон улсын эрх зүйн тогтолцоо” ном
2. Н.Долгорсүрэн “Эрх зүйн тогтолцоо” ном
3. “Солонгосын тухай танилцуулга” ном 2003 он
4. [www.naver.com](http://www.naver.com)
5. [www.daum.net](http://www.daum.net)